

НҮБ болон Арабын орнуудын лигийн тусгай толоологч Кофи Аннан оорийн энхийн толовлогоог хэрэгжүүлэх гэж оролдож байгаа Сири улсыг дэлхий дахин анхааралтай ажиглаж байна. Морголдож байгаа талууд эвлэрэх нохцол байдлыг хвлээж авах эсэх нь маргааш мягмар гаригт тодорхой болно. Энэ зохицуулалтад ОУ идэвхитэй зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байна. Москвад 4-р сарын 10-нд Сири улсын ГХЯ-ны сайд Валид Муаллем хэлэлцээр хийнэ. Харин долоо хоногийн дараа энд Дамаскын сирийн сорог хвчний толоологчид хврэлцэн ирэх юм.

Кофи Аннанаас юу хвлээж болох вэ? ОУ ямар зорилго баримтлаж байна вэ? “Оросын дуу хоолой” радиогийн шинжээч Елена Супонинагийн авсан жич ярилцлагад ГХЯ-ны сайд асан, академч Евгений Примаков ингэж хариулсан байна.

Асуулт: Кофи Аннаны томилогоо амжилтанд хврнэ гэдэгт ихэнх хвмвс эргэлзэж байсан. Мэдээж хэрэг хвндрэлтэй асуудалтай тулгарч байсан ч гэлээ тэрээр зарим нэг звйлийг хийж чадсан. Жишээ нь, зохицуулах толовлогоо боловсруулж, твннийг мордохийг сирийн засгийн газраар зовшоорвулж чадсан зэрэг ажлууд байна. Та Аннанд итгэж байсан уу?

Е.Примаков: « Би Кофи Аннаныг аль эртнээс мэднэ. Кофи Аннан бол маш ухаантай, ноён нуруутай хвн. АНУ болон европын улсууд дэмжиж байгаа нэг талыг тэр баримтлахгвй. Тэрээр нохцол байдалд бодитойгоор хандана гэдэгт би итгэлтэй байна. Сири улсын хувьд гэх юм бол хоёр талаас гал зогсоох нохцлийг бврдүүлэх нь зайлшгвй чухал юм. Зовхон засгийн газрыг буруутгаж твннээс нэг талын вйл ажиллагаа шаардаж, тэгсэн хирнээ далдуур сорог хвчнийг оогшввлж, зэвсэг нийлввлж болохгвй швв дээ. Кофи Аннан ийм чиг шугамыг баримтлахгвй гэдгийг би шууд л ойлгосон. Тэр внэхээр Орос, Хятад улсууд болон бусад олон улсуудын сайшаасан тийм толовлогоог санал болгосон юм. Одоо энэ толовлогоог яаж хэрэгжүүлэх вэ? гэдэг л чухал байна. Хоёр тал галыг нэн даруй зогсоох нь хамгийн гол нохцол байгаа швв дээ».

Асуулт: Сирийн засгийн газар ввнийг бараг зовшоороод байгаа швв дээ?

Е.Примаков: «Тиймээ, сирийн засгийн газар үүнийг зовшоороод зогсоогүй тодорхой хугацаа хүртэл тавиад байгаа шүү дээ. Та оороо санаж байгаа байх, саяхан “Сирийн анд ноход”-үүд цуглараад сирийн сорог хүчнийг зэвсэглэх тухай хэлэлцэж байсан шүү дээ. Ийм уулзалт болсны дараа засгийн газар цэрэг техникээ хотоос гаргасны дараа сорог хүчнийхэн тэдэн рүү дайрахгүй гэсэн баталгаа байна уу? Энэ ажиллагааг зовхон Сири улсын засгийн газартай бус сорог хүчнийхэнтэй бас явуулах ёстой юм. Бид болоод хятадууд яг ийм ажлыг л засгийн газартай явуулж байгаа юм. Харин иймэрхүү ажлыг сорог хүчинтэй хийж байгаа юм харагддаггүй л юм байна. Харин тэр “анд нохдүүд” гээд байгаа улсууд сорог хүчнийг оогшүүлж бүр зэвсэглэж байх шиг л байна даа».

Асуулт: Тэгэхлээр Сири улс дахь Асадыг дэглэмийг түлхэн унагах нь Барууныхны зорилго гэж үзэж болох уу?

Е.Примаков: «Барууныхан Асадын дэглэмийг түлхэн унагаахыг ихэд хүсэж байгаа. Бас Катар, Саудын Арав зэрэг арабын улсууд дэглэмийг унагаахыг сонирхож байгаа юм. Тэд “шиитийн бүс” гэгчийг бий болгохгүй байж түүнээс Сири улсыг гаргахыг хүсэж байгаа юм. “Шиитийн бүс” гэдэгт би, хүн амын ихэнх нь шиит лалууд Иран, Ирак улсууд, мөн Сири улсад их ойр байдаг шиитүүдийн байр суурь нилээд хүчтэй Ливан улсыг багтааж байгаа юм. Шиитийн цоонхүүд амьдардаг Персийн булангийн арабын орнууд үүнээс ихэд айж байгаа юм».

Асуулт: Сири улсад иргэний дайн болох магадлал хэр байна гэж та үзэж байна вэ?

Е.Примаков: «Иргэний дайн бараг эхлээд байна даа. Хэрвээ зовшилцож чадахгүй бол улам л гаарах байх. Энэ дайн нь шиитүүдтэй тосоотэй шашинтай алавит болон суннитуудын хооронд шашин хоорондын дайн болж хувирах байх. Хэрвээ ийм байдалд хүрвэл энэ нь цус урсгасан дайн болно».

Асуулт: Оороор хэлвэл ираныг сулруулах давхар зорилго байгаа бололтой. Ираны дэглэмийг солих бэлтгэл ажил ч гэж хэлж болох бол уу?

Е.Примаков: «Ямар нэг байдлаар энэ нь тийм юм. Маш ойлгомжтой учир шалтгаанаар Дамаск, Тегеранд ойртсон юм. Сиричүүд Израильтай нүүр нүүрээрээ халз тулан үлдэхээс айж байсан юм. Тэдэнд найдвартай ар тал хэрэгтэй байсан. Иран улс

сирүүдийн хувьд тэр ар тал нь болж чадсан юм».

Асуулт: Дараа долоо хоногт Москвад сирийн сорог хвчний толоогчид хүрэлцэн ирэх гэж байна. Энэ удаа Дамаскын сорог хвчнийхэн ирэх юм байна. ОУ-д сорог хвчнийхэнтэй харьцах хэрэг байгаа юм уу?

Е.Примаков: «Заавал шаарлагатай. Бид ямар нэгэн хувиа хичээсэн зорилгогүй, Сири улсад л энх тайван тогтоож, аль ч талаас хвч хэрэглэхгүй байхыг хвсэж байгаа гэдгийг бvхэнд харуулах ёстой юмаа» гэж академикч Евгений Примаков тогсголд нь онцлон тэмдэглэлээ.